

## **БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АГУУЛАХАД ТАВИГДАХ ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

(Ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, бодын хөөвөр, хялгасыг угаах, самнах  
үйлдвэрийн бүтээгдэхүүн хадгалах агуулах)

### **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

- 1.1 Агуулахын эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 1.1.1 Монгол улсын хуулийн этгээд байх;
  - 1.1.2 Бүрэн ажиллагаатай угаах ба самнах шугамтай, ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, хөөвөр, хялгас угаах үйл ажиллагаа явуулдаг үйлдвэртэй байх;
  - 1.1.3 Агуулах, ажлын байрыг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах эрхтэй байх;
  - 1.1.4 Хугацаа хэтэрсэн (татвар, банкны болон бусад) өргүй байх;
  - 1.1.5 Үндсэн ажилчдын (удирдах ажилтнууд хамаарахгүй) тоо 5-аас доошгүй, тэдгээр нь нийгмийн даатгалд хамрагдсан байх;
  - 1.1.6 Агуулах дахь биржийн барааг хариуцах мэргэшсэн бараа, түүхий эдийн мэргэжилтэнтэй байна.
- 1.2 Агуулахын эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: агуулахуудыг
  - 1.2.1 Монгол улсын MNS 5364:2011 стандартын шаардлагыг хангасан, 24 цагийн харуул хамгаалалттай, агуулахуудыг камержуулсан байх;
  - 1.2.2 Агуулахын хашаа нь биржийн барааг саадгүй ачих, буулгах боломжтой, тээврийн хэрэгсэл зогсох, хөдлөх хангалттай талбайтай байх;
  - 1.2.3 Биржийн хүлээн зөвшөөрсөн дараах тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон байна. Үүнд:
    - Стандартчилал хэмжилзүйн газраас баталгаажуулсан гэрчилгээ бүхий баталгаат жин, пүү;
    - Пресслэгч (шахуургын) төхөөрөмж;
    - Өргөх, буулгах, ачих төхөөрөмж;
  - 1.2.4 Биржийн агуулахын бүртгэлийн програмыг саадгүй ажиллуулах боломжтой компьютер, принтер, 1mb-аас доошгүй хурдтай интернэт, 4mb нягтралтай IP камер зэрэг дагалдах тоног төхөөрөмжтэй байх;
  - 1.2.5 Барааны бүртгэл хөтлөх ажилтантай байна.

### **ХОЁР. БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

- 2.1 Итгэмжлэл хүсэгч нь дараах баримт бичгийг Биржид бүрдүүлж өгнө. Үүнд:
  - 2.1.1 Итгэмжлэл хүссэн өргөдөл;
  - 2.1.2 Агуулахын албан ёсны болон байршил тодорхойлох хаяг, байнга харилцах утас, имэйл хаяг;

- 2.1.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүний хуулбар;
  - 2.1.4 Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түүний хуулбар;
  - 2.1.5 Дэд бүтцийн талаарх мэдээлэл (цахилгаан, цэвэр, бохир ус, интернэтийн гэрээ) түүний хуулбар;
  - 2.1.6 5-аас цөөнгүй ажилчдын (удирдах ажилтнууд хамаарахгүй) нийгмийн даатгалын дэвтэр, түүний хуулбар;
  - 2.1.7 Татвар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, түүний хуулбар;
  - 2.1.8 Агуулахын тоног төхөөрөмжийн талаарх бүрэн мэдээлэл;
  - 2.1.9 Агуулах тус бүрийн 4 талаас авсан гаднах, 8 зүгт авсан доторх зураг (хэвлэмэл, 8х12-оос доошгүй хэмжээтэй, дөрвөн булан, хана, шал, тааз, хаалга, тоног төхөөрөмж, хураах тавцанг харуулсан);
  - 2.1.10 Итгэмжлэлийн гэрчилгээний нэг удаагийн хураамж болох 300,000 (гурван зуун мянган) төгрөгийг
    - Хаан банк 5131004545,
    - Төрийн банк 106000999991 эдгээрийн аль нэг дансанд тушаасан баримт
- 2.2 Бүрдүүлэх баримт бичгийн 2.1.1, 2.1.2 заалт дахь баримтыг албан бичгээр үйлдэж, тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байна.
- 2.3 Бүрдүүлэх бичиг 2.1.3, 2.1.4, 2.1.5 заалт дахь баримтыг эх хувиар нь авчрах боломжгүй бол нотариатаар тухайн онд баталгаажуулсан хуулбарыг авчирч болно.
- 2.4 Бирж баримт бичгийн бүрдлийг хянан Итгэмжлэлийн гэрээ байгуулахыг зөвшөөрсөн тохиолдолд итгэмжлэл хүсэгч нь Биржийн мэдэгдлийн дагуу, итгэмжлэлийн хураамжийг тушааж баримтыг хавсаргасан байна.
- 2.5 Биржтэй итгэмжлэлийн гэрээ байгуулан ажилласан хугацаа, гэрээний үүргийн биелэлт, програм ашиглалтын найдвартай байдал зэргийг харгалзан гүйцэтгэх захирлын тушаалаар гэрээний хугацааг 1-3 жилээр байгуулна.

—oOo—